

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СИСТЕМИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь	ХШҮ-ний хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил			
ЗОРИЛТ 1.1 Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулсан байна.									
1.	Арга хэмжээ 1.1.1 Хуулийн төсөл боловсруулах, хуулийн шинэчилсэн найруулга, журам боловсруулах ажлын хэсэгт ажиллах	Урсгал төсөв	Ажлын хэсэг (тоо)	-	1	-	Аймаг, дүүргийн мэргэжлийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх талаар процесс, үйл ажиллагааны дарааллыг боловсруулж, танилцуулгад тусгах санал бэлтгэн, хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга боловсруулахад хамтран ажилласан. Төрийн хяналтын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг танилцуулах хэлэлцүүлэгт оролцсон.	90%	90%
ЗОРИЛТ 1.2 Үр дүнд суурилсан үнэлгээ, мониторингийн тогтолцоог нэвтрүүлсэн байна.									
2.	Арга хэмжээ 1.2.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээний системийн ажлын даалгавар боловсруулах, системийг хөгжүүлэх бэлтгэл ажлыг хангах	Урсгал төсөв	Батлуулсан ажлын даалгаврын тоо	-		1	Хяналт-шинжилгээ, үнэлгээний системийн ажлын даалгаврыг Дэлхийн банкнаас ирүүлсэн санал, зөвлөмжийн дагуу шинэчлэн боловсруулж, 2026.01.15-ны өдөр холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.	80%	80%
3.	Арга хэмжээ 1.2.2	Урсгал төсөв	Дэмжлэг үзүүлсэн арга	6	3	3	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай	80%	80%

	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх.		хэмжээний тоо				мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилэн ажилласан. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар (ags.gov.mn) цахим хуудсанд байгууллагын ил тод байдал, худалдан авах ажиллагаа, хүний нөөцийн стратеги, байгууллагын үйл ажиллагааны тайлан, албан хаагчдын мэдээллийг шинэчлэн оруулсан. 2025 оны жилийн эцсийн байгууллагын гүйцэтгэлийн тайлан, Газруудын гүйцэтгэлийн тайланг нэгтгэж ags.gov.mn цахим хуудсанд нийтэд нээлттэй байдлаар байршуулсан. Eрoнгoлiа хуудсанд байрлах Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын цахим хуудсанд 7 хоногт 1-2 мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэн оруулж байна.		
ЗОРИЛТ 2.1 Засгийн газрын хяналт, шалгалтын үйл ажиллагааны үр нөлөө дээшилсэн байна.									
4.	Арга хэмжээ 2.1.1 Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын чиг үүрэгт хамаарах асуудлаар хүн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдолд мэдээлэл технологийн чиглэлээр тандан судалгаа, шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх.	Урсгал төсөв	Гүйцэтгэлийн хувь	100	50%	50%	ЗГХХГ-ын даргын 2026.01.19-ний өдрийн А/05 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, Засгийн газрын хяналт шалгалтын тайлан боловсруулах хүрээнд өргөдөл, гомдлын мэдээллийг нэгтгэх, боловсруулалт хийх, дүн шинжилгээ хийх ажлуудад мэдээллийн технологийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Их өгөгдлийн нэгдсэн дашбоардад өргөдөл, гомдлын нэгдсэн санг холболт хийсэн.	100%	100%
ЗОРИЛТ 2.2 Хяналт, үнэлгээ, мониторинг, тандалт судалгааны үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн байгууллагын оролцоо нэмэгдсэн байна.									
5.	Арга хэмжээ 2.2.1 Мэдээллийн технологийн үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд төрийн болон бусад байгууллагын төлөөлөл, мэргэжилтэн, шинжээчтэй хамтран ажиллах	Урсгал төсөв	Хамтран гүйцэтгэсэн арга хэмжээний тоо	1	1	1	Байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглах "бодлогын тандалт, судалгаа хийх аргачлал"-д санал боловсруулж 2026.03.24-ий 06/06 дугаартай дотоод албан бичгээр ТСБТГ-т хүргүүлсэн. "Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөө /2026-2035/"-ний төсөлд санал боловсруулан, 2026.03.25-ны 06/07 дугаартай дотоод албан бичгээр хүргүүлсэн.	100%	70%

ЗОРИЛТ 4.1 Цахим технологийн оновчтой шийдэлд тулгуурласан мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлсэн байна									
6.	Арга хэмжээ 4.1.1 Өргөдөл гомдлын мэдээллийн санг баяжуулан, судалгаа шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэн, их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих дашбоардад холбох	Урсгал төсөв	Мэдээлэл нийлүүлж байгаа төрийн байгууллагын тоо	1500	1500	1500	Өргөдөл гомдлын мэдээллийн санг өргөтгөн, бодит цагийн (real-time) горимд ажиллах боломжтой болгож, судалгаа шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэн, их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих дашбоардад 1500 байгууллага холбогдсон байгааг эхний хагас жилийн байдлаар 30 байгууллагаар нэмэгдүүлээд байна. 2026.06.10-ны өдрийн байдлаар нийт 669 байгууллагын 66680 өргөдөл нэгдсэн системд бүртгэгдсэн байна.	100%	100%
7.	Арга хэмжээ 4.1.2 Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангасан байх	Урсгал төсөв	Хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан эсэх (Тийм-1, Үгүй-0)	1		1	Байгууллагын албан хэрэглээний интернэт холболтын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан. Байгууллагын тоон мэдээлэл дамжуулах сүлжээ, мэдээллийн аюулгүй байдлыг хангах галт хана хамгаалалтын төхөөрөмж худалдан авах гэрээг байгуулсан. Байгууллагын дотоод сүлжээний холболтын өдөр тутмын хэвийн ажиллагааг ханган ажилласан. Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний холболт, хэвийн ажиллагааг ханган ажилласан. Өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа утасгүй сүлжээний WiFi төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг ханган ажилласан. Байгууллагын серверийн өрөөнд хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг ханган ажилласан.	100%	100%
8.	Арга хэмжээ 4.1.3 Төрийн байгууллагын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа цахим системд шинжилгээ хийх, санал зөвлөмж өгөх	Урсгал төсөв	Байгууллагын тоо	6	1	1	Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан зорилт, арга хэмжээний хүрээнд төрийн үйлчилгээ, үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэж байгаа байдалд дүн шинжилгээ хийх, цаашид сайжруулах асуудлаар тандалт	100%	100%

							судалгаа хийж, дүгнэлт, санал боловсруулах үүрэг бүхий Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, "И-Монголиа академи" УТҮГ, Үндэсний Дата төв" УТҮГ зэрэг байгууллагын албан хаагчдаас бүрдсэн хамтарсан ажлын хэсгийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/147 дугаар тушаалаар байгуулж тандан, судалгаа хийснийг Засгийн газрын 2 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит хуралдаанд танилцуулан Ерөнхий сайдын 02 тоот албан даалгавар гарсан.		
9.	Арга хэмжээ 4.1.4 Мэргэжлийн хяналтын цахим системийг хөгжүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх, цахим мэдээллийн сангийн мэдээллийн аюулгүй, хэвийн ажиллах нөхцөлийг хангасан байна.	Урсгал төсөв	Системийн тоо	1	1	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн "Хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн систем" нэвтрүүлэх ажлын системийн хөгжүүлэлтийн суурь баримт бичиг болох ажлын техникийн даалгаврыг боловсруулсан. Уг ажлын хүрээнд дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд: - Хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглагдаж буй одоогийн цахим системүүдийн нөхцөл байдал, мэдээллийн урсгал, өгөгдлийн бүтэц болон техникийн боломжид шинжилгээ хийсэн. - Хяналт шалгалтын үйл ажиллагаанд оролцогч байгууллага, байцаагчид болон холбогдох албан тушаалтнуудын бодит хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор мэдээлэл цуглуулах, судалгаа хийх ажлыг зохион байгуулсан. - Системийн шинэчлэлийн ажлын хүрээ, оролцогч талууд, системийн үндсэн шаардлага, функцүүдийг тодорхойлж, системийн ерөнхий архитектур, хөгжүүлэлтийн чиглэлийг тодорхойлсон. - Цуглуулсан шаардлагуудыг нэгтгэн системд зайлшгүй хэрэгжих үндсэн функц, үйл ажиллагааны процесс, өгөгдлийн	70%	70%	

							удирдлагын шаардлагуудыг тодорхойлон техникийн даалгаварт тусгасан.		
10.	Арга хэмжээ 4.1.5 Хяналт шалгалтын дүн, тайлан, судалгаа болон өөрийн үйл ажиллагаанд хамаарах хуулиар нууцад хамааруулснаас бусад мэдээллийг нийтэд ил тод байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх.	Урсгал төсөв	Мэдээллийн ил тод байдлыг хангасан эсэх тийм-1, үгүй-0	1		1	Байгууллагын ags.gov.mn вэб хуудасны "судалгаа" цэсэнд тандалт судалгаа, шинжилгээ, процессын дахин инженерчлэлийн тайланг байршуулсан.	100%	100%
11.	Арга хэмжээ 4.1.6 Төрийн байгууллагын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, үнэлэх, хариу арга хэмжээ авах, хэрэгжилтэд үнэлгээ хийх системийг хөгжүүлэх бэлтгэл ажлыг хангах	Урсгал төсөв	Систем хөгжүүлэлт (хувь) Мэдээллийн сангийн хэрэгжилт (хувь)	1		30%	Төрийн байгууллагын эрсдлийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сан үүсгэх тухай ажлын даалгаварт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 2026.03.12-ны өдөр ажлын даалгаврыг батлуулсан. Төрийн захиргааны байгууллагууд ашигладаг Абле системд эрсдэлийн модуль оруулах талаар хамтран ажиллаж байна.	60%	50%
Зорилт 4.3. Мэдлэг, инновац, технологид суурилсан байгууллагын өөрчлөлтийн менежментийг хэрэгжүүлсэн байна.									
12.	Арга хэмжээ 4.3.1 Мэдлэг, инновац, технологид суурилсан сайн туршлага/арга хэмжээг байгууллагын дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлэх	Урсгал төсөв	Арга хэмжээний тоо	-		1	Төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, үр дүнд хяналт-шинжилгээ хийхэд хиймэл оюун ашиглах чиглэлээр "Блак Лабс" ХХК-тай хамтран ажиллах 26/01 дугаартай санамж бичгийг 2026.03.13-ны өдөр байгуулан ажиллаж байна.	90%	70%
5. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ									
13.	Арга хэмжээ 5.1 Монгол Улсын Тэргүүн Шадар сайд, байгууллагын удирдлагыг цаг үеийн мэдээ, мэдээллээр хангах, мэргэшлийн болон арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах	Урсгал төсөв	Гүйцэтгэлийн хувь	-	50%	50%	Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах "Government Planning System v4.0" системийг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт боловсруулах үйл ажиллагаанд ашиглах тухай 2026.03.16-ны өдрийн 01/318 дугаартай албан бичгийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайдад хүргүүлсэн. Монгол Улсын Тэргүүн Шадар сайдын 2025 оны жилийн хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайланд санал хүргүүлсэн.	100%	100%

14.	<p>Арга хэмжээ 5.2 Архив албан хэрэг хөтлөлтийн цахим архивын систем нэвтрүүлэх</p>	Хөрөнгө оруулалт	Цахим архивын систем нэвтрүүлсэн эсэх (Тийм-1, Үгүй-0)	-		1	<p>Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор “цахим архивын системийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх” ажлын даалгаврыг боловсруулж, 2023.03.10-ны өдөр газрын даргаар батлуулсан.</p> <p>Үнэлгээний хороо байгуулах тухай 2026.03.12-ны өдрийн А/22 дугаартай тушаалаар “Цахим архивын системийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан.</p> <p>“Цахим архивын системийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЗГХХГ/20260202038 тендер шалгаруулалтын дугаартай тендерийн баримт бичгийг боловсруулж, үнэлгээний хорооны нарийн бичигт хүргүүлсэн. Тус тендерт “Ньюсоник” ххк шалгарч 05 дугаар сарын 25-ны өдөр гэрээ “Цахим архивын системийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх цахим архивын EDOC систем нийлүүлэх гэрээ” байгуулж хэрэглээнд нэвтрүүлсэн.</p>	100%	100%
15.	<p>Арга хэмжээ 5.3 Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагддаг сүлжээ, систем, программ хангамж, техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангах</p>	Хөрөнгө оруулалт	Хэвийн ажиллагаа, аюулгүй байдал хангагдсан эсэх (Тийм-1, Үгүй-0)	-		1	<p>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын тоон мэдээлэл дамжуулах сүлжээ, интернэт сүлжээ, сервер тоног төхөөрөмжийн өдөр тутмын тасралтгүй, найдвартай, хэвийн ажиллагааг тогтмол ханган ажилласан.</p> <p>Газрын даргын А/20 тоот тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний ЗГХХГ/20260203033 тендер шалгаруулалтын дугаартай барааг худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороо байгуулагдсан. Үнэлгээний хороонд Дотоод сүлжээний дэд бүтэц сайжруулах ажлын тендерийн баримт бичгийн төсөл болон системийн ажлын даалгавар батлуулж хүргүүлсэн. Дотоод сүлжээний дэд бүтэц сайжруулах ажлын даалгавар боловсруулж</p>	100%	70%

							2026.03.10-ны өдөр батлуулсан. Тус тендерт "Топика" ххк шалгарч 05 дугаар сарын 22-ны өдөр гэрээ байгуулж Дотоод сүлжээний дэд бүтэц сайжруулсан.			
6. КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ										
16.	Арга хэмжээ 6.1.1 Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам боловсруулж, батлуулах	Урсгал төсөв	Батлуулсан журмын тоо	-		1	"Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам"-ын төсөл боловсруулсан. Газар, хэлтсээс санал авсан. Журмын төсөлд ирсэн саналыг тусгаж байгууллагын даргад танилцуулахаар ажиллаж байна.	80%	70%	
17.	Арга хэмжээ 6.1.2 Байгууллага кибер халдлага, зөрчилд өртсөн мэдээллийн систем, мэдээллийн сүлжээг нөхөн сэргээх үйл ажиллагааг хариуцах албан тушаалтан, үйл ажиллагааны дарааллыг тодорхойлсон нөхөн сэргээх төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх, кибер аюулгүй байдлыг хангах стратеги төлөвлөгөөг байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах	Урсгал төсөв	Батлуулсан төлөвлөгөөний тоо	-		1	Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 8.4-т заасны дагуу, байгууллагын кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 09-ний өдрийн хооронд Тагнуулын ерөнхий газраар хийлгэсэн. Кибер аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээтэй холбоотой зөвлөмжийг 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн. Энэ ажлын хүрээнд кибер аюулгүй байдлыг хангах стратеги төлөвлөгөөний төслийг байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж байна.	70%	50%	
18.	Арга хэмжээ 6.1.3 Мэдээллийн технологи, кибер аюулгүй байдал хариуцсан ажилтан, албан хаагчийн мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэх арга хэмжээ авах	Хөрөнгө оруулалт	Сургалтын тоо	-		2	3	Мэдээллийн аюулгүй байдлын аудит, дата анализ чиглэлийн сургалтанд мэдээллийн технологи, кибер аюулгүй байдал болон тандалт судалгаа, бодлого төлөвлөлт хариуцсан албан хаагчид, Мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг олгох сургалт болон хиймэл оюуны сургалтад нийт албан хаагчдыг хамруулах саналыг "2026 онд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө"-д тусгуулахаар 2026.02.28-ны өдрийн 06/04 дугаартай дотоод албан бичгээр Тамгын газарт хүргүүлсэн. Төлөвлөгөөний дагуу албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулна.	100%	70%

							Мэдээллийн технологи, кибер аюулгүй байдал хариуцсан ажилтан, албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын зардал худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан.		
19.	Арга хэмжээ 6.1.4 Мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний ачааллыг тогтмол, эсхүл 24/7 горимоор хянах; мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний эмзэг байдлын шалгалтыг тогтмол хийх	Урсгал төсөв	Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь	-	50%	50%	Байгууллагын тоон мэдээлэл дамжуулах сүлжээ, мэдээллийн аюулгүй байдлыг хангах галт хана хамгаалалтын төхөөрөмж худалдан авах гэрээг байгуулсан. Уг галт хана төхөөрөмжийг хүлээн авч суурилуулсан. Мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний эмзэг байдлын шалгалтыг тогтмол хийх боломж бүрдсэн.	100%	100%
20.	Арга хэмжээ 6.2.1 Мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний үйлдлийн бүртгэлийг тогтмол цуглуулж, тайлан гаргах, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх	Урсгал төсөв	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	1		Галт хана төхөөрөмж суурилуулснаар Мэдээллийн сүлжээний үйлдлийн бүртгэлийг тогтмол цуглуулж тайлан гаргах, дүн шинжилгээ хийх боломж бүрдсэн.	100%	100%
21.	Арга хэмжээ 6.3.1 Байгууллага мэдээлэл, түүнийг агуулж байгаа мэдээллийн систем, мэдээллийн сүлжээг хортой кодоос хамгаалах программ хангамж ашиглах	Хөрөнгө оруулалт	Програм хангамжийн тоо	-	70	70	ЗГХХГ-ын даргын 2026.03.06-ны өдрийн А/15 дугаартай тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ЗГХХГ/20260602040 тендер шалгаруулалтын дугаартай бараа "Antivirus Program лиценз "худалдан авахаар туссан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Гэрээ байгуулахаар ажиллаж байна.	90%	70%
22.	Арга хэмжээ 6.3.2 Байгууллага нь мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд тохирсон аюулгүй байдлыг хангах систем (IDS/IPS, antimalware, WAF, Email filter, SIEM)-ийг хэрэглэх (Галт хана төхөөрөмж тохируулж, суурилуулах)	Хөрөнгө оруулалт	Хамгаалалтын төхөөрөмжийн тоо	-	1	1	ЗГХХГ-ын даргын 2026.03.06-ны өдрийн А/15 дугаартай тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ЗГХХГ/20260602053 тендер шалгаруулалтын дугаартай бараа "Галт хана төхөөрөмж"-г худалдан авахаар тусгасан. 2026.03.20-ны өдөр "Ай Ти Зон" ХХК-тай 26/10 дугаартай гэрээ байгуулсан. Гэрээний хугацаанд бараа хүлээн авсан. Байгууллагын мэдээллийн систем,	100%	100%

							мэдээллийн сүлжээнд Галт хана төхөөрөмж тохируулж, суурилуулсан.		
23.	Арга хэмжээ 6.4.1 Байгууллагын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний тоног төхөөрөмж байрлаж байгаа зориулалтын өрөөг стандартын дагуу тохижуулах	Хөрөнгө оруулалт	Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь	-	50%	50%	Газрын даргын 2026.03.12-ны өдрийн А/21 тоот тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний ЗГХХГ/20260201032 тендер шалгаруулалтын дугаартай барааг худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороо байгуулагдсан. Сервер өрөөний тохижилт ажлын даалгавар боловсруулж 2026.03.10-ны өдөр батлуулсан. Тус тендерт "Топика" ххк шалгарч 05 дугаар сарын 22-ны өдөр "Сервер өрөөний тохижилт"-ын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Байгууллагын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний тоног төхөөрөмж байрлаж байгаа зориулалтын өрөөг стандартын дагуу тохижуулсан.	100%	100%

Төлөвлөгөөг үнэлсэн:

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ГАЗРЫН ДАРГА

Төсвийн шууд захирагч






П. БАТБААТАР/

2026. 06. 10 (огноо)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ДОТООД ХЯНАЛТ, АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА

Нэгжийн дарга



/Р. ДЭЖИД/

2026. 06. 16 (огноо)

Тайлагнасан:

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СИСТЕМИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА

Нэгжийн дарга



/С. БАТБААТАР/

2026. 06. 15 (огноо)